



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

“Мөнх даатгал” ХХК-д дүрмийн сан  
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн бүтэц,  
хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мөнх даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг тус компанийн 2011 оны хуримтлагдсан ашгаас нийт 100 000 000.00 /нэг зуун сая/ төгрөг, шинээр хувь нийлүүлэгчийн хөрөнгө оруулалтаас 515 000 000.00 /таван зуун арван таван сая/ төгрөг, нийт 615 000 000.00 /зургаан зуун арван таван сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгчдийн нэрс	Дүрмийн сангийн хэмжээ /мянган төгрөгөөр/				Дүрмийн санд эзлэх хувь /%/	
		Эхний үлдэгдэл	Хувь	Нэмэлт хөрөнгө оруулалт			Эцсийн үлдэгдэл
				Ашгаас	Бусад		
1	Ч.Отгонжаргал	486,980.0	48.70	48,700.0		535,680.0	33.17
2	Р. Нямсүрэн	256,520.0	25.70	25,650.0		282,170.0	17.47
3	Ч. Жигжид	256,500.0	25.60	25,650.0		282,150.0	17.47
4	Т.Оюунгэрэл				515,000.00	515,000.0	31.89
	<b>ДҮН</b>	<b>1,000,000.0</b>	<b>100.0</b>	<b>100,000.0</b>	<b>515,000.0</b>	<b>1,615,000.0</b>	<b>100.0</b>

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Мөнх даатгал” ХХК /Т. Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001583